**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

---

# Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: БНА-2024/051/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Баянхонгор хот<br>2025.02.07 | Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат<br>Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn<br>Аудитын менежер М.Алтантуяа<br>Утас: 99061829 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn<br>Аудитор Ц.Дорж<br>Утас: 88114307 Цахим хаяг: Dorjts@audit.gov.mn<br>Цахим хуудас: www.audit.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584
Цахим шуудан:procurement. bayankhongor@audit.gov.mn

2025.02.14 № 2/13

танай___________-ны № ___________ -т

СОЁЛ, УРЛАГ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ,
ЗАЛУУЧУУДЫН ГАЗРЫН ДАРГА
Б.ПҮРЭВДАГВА ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө,өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Албан хаагчдад олгосон албан томилолттой холбоотой зөрчил нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түшингээс хэтрээгүй болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

**Аудитын гол асуудал**

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын даргын 2024.04.03 -ний өдрийн 26 дугаар захирамжаар анхны өртөг нь 140,831.7 мянган төгрөг, хуримтлагдсан элэгдэл 21,338.1 мянган төгрөг, үлдэх өртөг 119,493.6 мянган төгрөгийн барилга,

5020152

9,700.0 мянган төгрөгийн газар, Соёлын яамны хөрөнгө оруулалтаар 67,500.0 мянган төгрөгийн фургон автомашин зэргийг үндсэн хөрөнгө дансанд бүртгэсэн байна.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 40 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 91.8 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ

[illegible]


[illegible] : procurement. bayankhongor@audit.gov.mn
[illegible] · 64101 · [illegible]: (976) 70442584
[illegible] 1 [illegible]
310 [illegible] 3


2024-02-20 [illegible]

5020115

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible] 91,8 [illegible]

[illegible] 40 [illegible]

[illegible]

[illegible] 67,500.0 [illegible] 119,493.6 [illegible] 9,700.0 [illegible] 140,831.7 [illegible] 21,338.1 [illegible] 2024.04.03 -[illegible] 26

[illegible]

АГУУЛГА

**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ** ..... 3
**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ** ..... 7
**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА** ..... 166
**4. АУДИТЫН ТАЙЛАН** ..... 20
**4.1 Ерөнхий зүйл** ..... 20
**4.2 Материаллаг байдал** ..... 20
**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт** ..... 20
**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал** ..... 21
**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт** ..... 21
**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт** ..... 21
**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал** ..... 21
**5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ** ..... 22
**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ** ..... 23

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ССАЖЗЯ | Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам |

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **10,756,939.0** | **3,674,946.0** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | - | - |
| **33** | **АВЛАГА** | 1,427,300.0 | - |
| **335** | **Бусад авлага** | 1,427,300.0 | - |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 1,427,300.0 | - |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 9,329,639.0 | 13,674,946.0 |
| **351** | **Түүхий эд материал** | 1,688,300.0 | 7,265,300.0 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 1,688,300.0 | 7,265,300.0 |
| **354** | **Хангамжийн материал** | 7,641,339.0 | 6,409,646.0 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,257,900.0 | 1,071,655.0 |
| 35420 | Аж ахуйн материал | 3,944,199.0 | 3,244,199.0 |
| 35450 | Барилгын засварын материал | 1,434,290.0 | 1,336,792.0 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 1,004,950.0 | 757,000.0 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **57,912,947.7** | **270,186,623.8** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 57,912,947.7 | 70,186,623.8 |
| **392** | **Биет хөрөнгө** | 56,412,947.7 | 258,986,623.8 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | - | 140,831,731.8 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | - | (24,272,134.4) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | - | 67,500,000.0 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | - | (5,625,000.0) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 40,340,150.0 | 64,519,150.0 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (11,418,142.9) | (21,201,127.2) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 30,233,101.0 | 47,792,101.0 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (2,742,160.5) | (10,558,097.4) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 1,500,000.0 | 11,200,000.0 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 1,500,000.0 | 11,200,000.0 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **68,669,886.7** | **283,861,569.8** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **68,669,886.7** | **283,861,569.8** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 68,669,886.7 | 83,861,569.8 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 68,669,886.7 | 283,861,569.8 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 68,669,886.7 | 68,669,886.7 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 215,191,683.1 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **68,669,886.7** | **283,861,569.8** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **411,279,188.0** | **56,549,399.3** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **906,900.0** | **199,813,591.8** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 906,900.0 | 199,813,591.8 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 906,900.0 | 199,813,591.8 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 906,900.0 | 199,813,591.8 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **410,372,288.0** | **556,735,807.5** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 328,249,600.0 | 472,464,700.0 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 328,249,600.0 | 472,464,700.0 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 81,438,650.0 | 65,043,980.0 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 22,384,000.0 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 59,020,000.0 | 65,000,000.0 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 34,650.0 | 43,980.0 |
| 131106 | Төсвийн урамшуулал | | |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | - | 19,227,127.5 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | - | 19,227,127.5 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 684,038.0 | - |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 684,038.0 | - |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **397,744,344.1** | **538,400,216.2** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **397,744,344.1** | **538,400,216.2** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 369,488,261.5 | 500,006,918.0 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 201,244,440.0 | 307,440,137.2 |
| 210101 | Үндсэн цалин | 123,317,100.0 | 189,440,153.0 |
| 210102 | Нэмэгдэл | 44,096,567.0 | 79,440,984.2 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 19,790,000.0 | 23,550,000.0 |
| 210104 | Урамшуулал | 11,578,334.0 | 15,009,000.0 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 2,462,439.0 | - |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 24,751,611.9 | 38,251,531.9 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 17,071,280.1 | 26,794,140.9 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,008,385.9 | 3,001,143.4 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,606,708.7 | 1,474,171.8 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 367,581.9 | 1,396,414.8 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,697,655.4 | 5,585,661.0 |

| | | | |
|---|---|---|---|
| 210206 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/ | | |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 11,070,006.5 | 19,253,842.2 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,698,053.0 | 2,244,474.0 |
| 210302 | Түлш, халаалт | 8,203,297.5 | 16,447,114.2 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,168,656.0 | 562,254.0 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 16,261,600.0 | 40,284,442.0 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,778,850.0 | 11,531,225.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 9,090,100.0 | 9,233,990.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 803,550.0 | 1,345,850.0 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 70,800.0 | 600,000.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,518,300.0 | 15,839,928.0 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | - | 1,733,449.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 6,512,110.0 | 8,606,999.0 |
| 210604 | Урсгал засвар | 6,512,110.0 | 8,606,999.0 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | - | 3,980,000.0 |
| 210702 | Дотоод албан томилолт | - | 3,980,000.0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 76,555,638.0 | 47,142,550.0 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 75,871,600.0 | 46,642,550.0 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | - | 500,000.0 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 684,038.0 | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 33,092,855.1 | 35,047,415.7 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 23,189,910.0 | 6,919,000.0 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | - | 1,808,000.0 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 9,902,945.1 | 26,320,415.7 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 28,256,082.6 | 38,393,298.2 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 26,040,135.0 | 16,742,099.8 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 23,300,135.0 | - |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | 14,942,099.8 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,740,000.0 | 1,800,000.0 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 2,215,947.6 | 21,651,198.4 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,215,947.6 | 21,651,198.4 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **13,534,843.9** | **218,149,183.1** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 6,238,628.4 | 2,957,500.0 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 372,628.4 | 2,957,500.0 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 5,866,000.0 | - |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | (6,238,628.4) | (2,957,500.0) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **7,296,215.5** | **215,191,683.1** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **410,372,288.0** | **556,735,807.5** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **410,372,288.0** | **556,735,807.5** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 328,249,600.0 | 472,464,700.0 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 328,249,600.0 | 472,464,700.0 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 81,438,650.0 | 65,043,980.0 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 22,384,000.0 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 59,020,000.0 | 65,000,000.0 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 34,650.0 | 43,980.0 |
| 131106 | Төсвийн урамшуулал | | |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | - | 19,227,127.5 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | - | 19,227,127.5 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 684,038.0 | - |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 684,038.0 | - |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **390,571,138.0** | **514,997,807.5** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **390,571,138.0** | **514,997,807.5** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **362,315,055.4** | **475,404,509.3** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 202,361,740.0 | 306,012,837.2 |
| 210101 | Үндсэн цалин | 124,434,400.0 | 188,269,888.0 |
| 210102 | Нэмэгдэл | 44,096,567.0 | 79,184,140.2 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 19,790,000.0 | 23,549,809.0 |
| 210104 | Урамшуулал | 11,578,334.0 | 15,009,000.0 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 2,462,439.0 | - |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 24,751,611.9 | 38,251,531.9 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 17,071,280.1 | 26,794,140.9 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,008,385.9 | 3,001,143.4 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,606,708.7 | 1,474,171.8 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 367,581.9 | 1,396,414.8 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,697,655.4 | 5,585,661.0 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 11,070,006.5 | 19,253,842.2 |

| | | | |
|---|---|---|---|
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,698,053.0 | 2,244,474.0 |
| 210302 | Түлш, халаалт | 8,203,297.5 | 16,447,114.2 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,168,656.0 | 562,254.0 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 5,968,799.0 | 16,545,840.0 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,488,250.0 | 3,600,000.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 590,100.0 | 5,999,990.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 803,550.0 | 1,345,850.0 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 70,800.0 | 600,000.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,016,099.0 | 5,000,000.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 7,946,400.0 | 6,392,000.0 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | 792,000.0 |
| 210604 | Урсгал засвар | 7,946,400.0 | 5,600,000.0 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | - | 3,980,000.0 |
| 210702 | Дотоод албан томилолт | - | 3,980,000.0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 102,569,488.0 | 77,569,530.0 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 101,885,450.0 | 77,069,530.0 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | - | 500,000.0 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 684,038.0 | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 7,647,010.0 | 7,398,928.0 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,647,010.0 | 3,400,000.0 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | - | 3,998,928.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **28,256,082.6** | **39,593,298.2** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 26,040,135.0 | 17,942,099.8 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 23,300,135.0 | - |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | 14,942,099.8 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,740,000.0 | 3,000,000.0 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 2,215,947.6 | 21,651,198.4 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,215,947.6 | 21,651,198.4 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **19,801,150.0** | **41,738,000.0** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **19,801,150.0** | **41,738,000.0** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **19,801,150.0** | **41,738,000.0** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 19,801,150.0 | 41,738,000.0 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 19,801,150.0 | 41,738,000.0 |

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 6 | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** (6)=(4)-(5) | **(19,801,150.0)** | **(41,738,000.0)** |
| 7 | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | - | - |
| 8 | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** (8)=(3)+(6)+(7) | - | - |
| 9 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| 10 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | | | 61,373,671.14 | | 61,373,671.14 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | | | **61,373,671.14** | | 61,373,671.14 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | 7,296,215.53 | | 7,296,215.53 |
| C08 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | | | **68,669,886.67** | | 68,669,886.67 |
| D01 | **2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | | | **68,669,886.67** | | 68,669,886.67 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | | | **68,669,886.67** | | 68,669,886.67 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | 215,191,683.14 | | 215,191,683.14 |
| D09 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | | | **283,861,569.81** | | 283,861,569.81 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хэтрэлт хэмнэлт | Хувь |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 472,464,700.0 | 454,456,803.1 | 18,007,896.9 | 96.2 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 472,464,700.0 | 454,456,803.1 | 18,007,896.9 | 96.2 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 453,685,700.0 | 436,514,703.3 | 17,170,996.7 | 96.2 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 306,954,700.0 | 291,534,344.0 | 15,420,356.0 | 95.0 |
| 210101 | Үндсэн цалин | 193,368,700.0 | 188,269,888.0 | 5,098,812.0 | 97.4 |
| 210102 | Нэмэгдэл | 68,531,200.0 | 64705647.0 | 3,825,553.0 | 94.4 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 23,566,900.0 | 23,549,809.0 | 17,091.0 | 99.9 |
| 210104 | Урамшуулал | 21,487,900.0 | 15,009,000.0 | 6,478,900.0 | 69.8 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 38,369,300.0 | 37,146,199.1 | 1,223,100.9 | 96.8 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 26,091,100.0 | 25,688,808.1 | 402,291.9 | 98.5 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,069,500.0 | 3,001,143.4 | 68,356.6 | 97.8 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,534,800.0 | 1,474,171.8 | 60,628.2 | 96.0 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,534,800.0 | 1,396,414.8 | 138,385.2 | 91.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,139,100.0 | 5,585,661.0 | 553,439.1 | 91.0 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 19,637,000.0 | 19,253,842.2 | 383,157.8 | 98.0 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,487,000.0 | 2,244,474.0 | 242,526.0 | 90.2 |
| 210302 | Түлш, халаалт | 16,450,000.0 | 16,447,114.2 | 2,885.8 | 100.0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 700,000.0 | 562,254.0 | 137,746.0 | 80.3 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 16,633,000.0 | 16,545,840.0 | 87,160.0 | 99.5 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,600,000.0 | 3,600,000.0 | 0.0 | 100.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 6,000,000.0 | 5,999,990.0 | 10.0 | 100.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,433,000.0 | 1,345,850.0 | 87,150.0 | 93.9 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 600,000.0 | 600,000.0 | 0.0 | 100.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5,000,000.0 | 5,000,000.0 | 0.0 | 100.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 34,600,000.0 | 34,571,000.0 | 29,000.0 | 99.9 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 25,000,000.0 | 24,971,000.0 | 29,000.0 | 99.9 |
| 210602 | Тавилга | 4,000,000.0 | 4,000,000.0 | 0.0 | 100.0 |
| 210604 | Урсгал засвар | 5,600,000.0 | 5,600,000.0 | 0.0 | 100.0 |

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ӨӨРЧЛӨЛТГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 4,000,000.0 | 3,980,000.0 | 20,000.0 | 99.5 |
| 210702 | Дотоод албан томилолт | 4,000,000.0 | 3,980,000.0 | 20,000.0 | 99.5 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 26,091,700.0 | 26,084,550.0 | 7,150.0 | 100.0 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 25,591,700.0 | 25,584,550.0 | 7,150.0 | 100.0 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 500,000.0 | 500,000.0 | 0.0 | 100.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 7400000.0 | 7398928.0 | 1072.0 | 100.0 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,400,000.0 | 3,400,000.0 | 0.0 | 100.0 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,000,000.0 | 3,998,928.0 | 1,072.0 | 100.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 18,779,000.0 | 17,942,099.8 | 836,900.2 | 95.5 |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | 0.0 | 0.0 | 0.0 | |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 18,779,000.0 | 17,942,099.8 | 836,900.2 | 95.5 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 0.0 | 0.0 | 0.0 | |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 15,779,000.0 | 14,942,099.8 | 836,900.2 | 94.7 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,000,000.0 | 3,000,000.0 | 0.0 | 100.0 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 472,464,700.0 | 454,456,803.1 | 18,007,896.9 | 96.2 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 0.0 | 0.0 | 0.0 | |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 472,464,700.0 | 454,456,803.1 | 18,007,896.9 | 96.2 |
| 122005 | Орон нутгийн төсвөөс | 472,464,700.0 | 454,456,803.1 | 18,007,896.9 | 96.2 |

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДУГНЭЛТ

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **79,038,650.0** | **84,271,107.5** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **79,038,650.0** | **84,271,107.5** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 79,038,650.0 | 80,627,806.0 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 79,038,650.0 | 14,478,493.2 |
| 210102 | Нэмэгдэл | | 14,478,493.2 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | | 1,105,332.8 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | | 1,105,332.8 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 79,038,650.0 | 65,043,980.0 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 79,038,650.0 | 65,043,980.0 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **0.0** | **3,643,301.5** |
| 213303 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг | 0.0 | 3,643,301.5 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 9,038,650.0 | **84,271,107.5** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 79,038.65 | **84,271,107.5** |
| | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 19,984,000.0 | |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 59,020,000.0 | 65,000,000.0 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 34,650.0 | 43,980.0 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага | | 19,227,127.50 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | |

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар нь "Төрөөс баримтлах соёлын бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх, орон нутгийн онцлог хэв шинж бүхий соёлын өвд тулгуурлах хүн амыг соён гэгээрүүлэх соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд оршино" гэсэн зорилго дэвшүүлэн ажилласан байна.

Тус байгууллага нь Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны дэвшүүлэн тавьсан зорилго зорилтыг хангах үүднээс байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулах чиг үүргийн дагуу орон нутгийн онцлог хэв шинж бүхий соёлын өвд тулгуурласан, соёлын бүтээлч үйлдвэрлэл, контентуудыг хөгжүүлэх замаар, бүсийн соёлын аялал жуулчлалын төв болж. Биет болон биет бус соёлын уламжлалыг өвлүүлэн дэлгэрүүлж, иргэдийн соёлын боловсрол, хандлагыг дээшлүүлэн, соёлын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

• Монгол Улсын Засгийн газрын 2024 оны "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 128 дугаар тогтоол

• Монгол Улсын Засгийн газрын 2024 оны "Тогтоолын хавсралт өөрчлөн батлах тухай" 82 дугаар тогтоол (Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгох журам)

• Монгол Улсын Засгийн газрын 2024 оны "Журам батлах, журмын хавсралтад өөрчлөлт оруулах тухай" 83 дугаар тогтоол (Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам)

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудит/аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Соёлын сайдын 2022 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн А/02 дугаар тушаалаар баталсан " Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт

ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

бичиг"-ийг үйл ажиллагаандаа ашиглаж, санхүүгийн тайлан бэлтгэхдээ мөрдөж ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар нь 2024 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйл 4.1.3-т Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 215,191.7 мянган төгрөг буюу 413.4 хувиар *өссөн* байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | | Эцсийн үлдэгдэл | | Эцсийн үлдэгдэл | |
|---|---|---|---|---|---|---|
| | дүн | эзлэх хувь | дүн | эзлэх хувь | дүн | эзлэх хувь |
| ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 10,756.9 | 15.7 | 13,674.9 | 4.8 | 2,918.0 | 1.36 |
| МӨНГӨН ХӨРӨНГӨ | - | | - | | - | |
| АВЛАГА | 1,427.3 | 13.30 | - | | (1,427.3) | |
| УРЬДЧИЛГАА | - | | - | | - | |
| БАРАА МАТЕРИАЛ | 9,329.6 | 86.7 | 13,674.9 | 4.82 | 4,345.3 | 1.36 |
| НӨӨЦИЙН БАРАА | - | | - | | - | |
| ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 57,912.9 | 84.3 | 270,186.6 | 95.2 | 212,273.7 | 98.64 |
| ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 72,073.2 | 104.9 | 331,842.9 | 116.9 | 259,769.7 | 120.72 |
| ХУРИМТЛАГДСАН ЭЛЭГДЭЛ | (14,160.3) | (20.6) | (61,656.3) | (21.7) | (47,496.0) | 22.08 |
| **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **68,669.9** | **100** | **283,861.6** | **100** | **215,191.7** | **100** |
| НИЙТ ӨР ТӨЛБӨР | 0.0 | | 0.0 | | (0.00) | |
| ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 68,669.9 | 100 | 283,861.6 | 100 | 215,191.7 | 100 |
| **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **68,669.9** | **100** | **283,861.6** | **100** | **215,191.7** | **100** |

Авлагын данс эхний үлдэгдэл 1.427.3 мянган төгрөгийн хувь хүмүүсээс авах авлагатай байсныг барагдуулсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 13,674.9 мянган төгрөг болж өмнөх оноос 4,345.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Төсвийн худалдан авалтаар 58,209.9 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч, 52,131.1 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан нь бараа материалын данс өсөхөд голлох нөлөө үзүүлжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 331,842.9 мянган төгрөг болж 259,769.7 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн худалдан авалтаар 9 нэр төрлийн 24,179.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 9 нэр төрлийн 17,559.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, Соёлын яамны хөрөнгө оруулалтаар 67,500.0 мянган төгрөгийн фургон автомашин, 3,120.0 мянган төгрөгийн суурин компьютер, Аймгийн иргэдийн

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

төлөөлөгчдийн хурлын даргын 2024.04.03 -ний өдрийн 26 дугаар захирамжаар биет бус хөрөнгө дансанд 9,700.0 мянган төгрөгийн газрыг, барилга байгууламж дансанд анхны өртөг 140,831.7 мянган төгрөг, хуримтлагдсан элэгдэл 21,338.1 мянган төгрөг, үлдэх өртөг 119,493.6 мянган төгрөгийн барилгыг орлогод авч. Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын даргын 2024.11.18 -ний өдрийн 100 дугаар захирамжаар машин тоног төхөөрөмж данснаас 3,120.0 мянган төгрөгийн суурин компьютерыг балансаас балансад шилжүүлсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 283,861.6 мянган төгрөг болж 215,191.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээр хуримтлагдсан 215,191.7 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 732,389.1 мянган төгрөгөөр тооцон зардлыг санхүүжүүлэхээр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 327,199.3 мянган төгрөгөөр бууруулж 405,189.8 мянган төгрөгөөр баталсан байна. 2024 оны 9 дүгээр сард бүтцэд өөрчлөлт орж Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар болж өргөжсөнтэй холбоотойгоор Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яаманд хүсэлт явуулсны үндсэн дээр 67,274.9 мянган төгрөгийн санхүүжилтийг нэмэгдүүлсэн холбоотой байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд улсын төсвийн санхүүжилтээр 556,735.8 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлснээс урсгал үйл ажиллагаанд 535,084.6 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 535,084.6 мянган төгрөг буюу 96.1 хувьтай байгаа нь 4 орон тоо дутуугаас болж цалин болон ажил олгогчоос төлөх НДШ-ийн 16,643.4 мянган төгрөг зарцуулаагүй нь голлох нөлөөг үзүүлж байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | 80101 Үндсэн үйл ажиллагааны зардал | 523,990.1 | 503,176.5 | 20,813.6 | 96.7 |
| 2 | 80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, | 18,779.0 | 17,942.1 | 836.9 | 95.5 |
| 3 | 83115 Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрүүд, | 13,966.7 | 13,966.0 | 0.7 | 100 |
| 4 | Дүн | 556,735.8 | 535,048.6 | 21,651.2 | 96.1 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар орон нутгийн санхүүжилт 19,227.1 мянган төгрөг, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны санхүүжилт 65,000.0 мянган төгрөг, үйл ажиллагааны бус орлого 43.9 мянган төгрөг нийт 84,271.1 мянган төгрөг хуваарилсныг 14,478.5 мянган төгрөгийг нэмэгдэл цалинд, 1,105.3 мянган төгрөгийг ажил олгочоос төлөх НДШ-д, 65,043.9 мянган төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжид, зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тус байгууллага нь RMB XXK -тай халаалтын гэрээ хийж тайлант оны эхэнд батлагдсан төсөвт түлш халаалтын зардал нь 8,500.0 мянган төгрөгөөр батлагдаж, дулаан хангагч байгууллагад өглөгтэй болсны үндсэн дээр 2024 оны 12 сард төсвийн хуваарьт зохицуулалт хийлгүүлж халаалтын зардалд 7,950.0 мянган төгрөгийг нэмж батлуулсан байна.

Тус байгууллага нь түлш халаалтын зардалд нийт 16,450.0 мянга, гэрэл цахилгааны зардалд 2,487.0 мянга, цэвэр бохир усны зардалд 700.0 мянган төгрөг батлагдсанаас RMB XXK дулаанаар хангах гэрээ, “Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК, цахилгаанаар хангах гэрээ, Чандмань Баянхонгор ХК цэвэр бохир усны гэрээг тус тус байгуулж ажилласан байна.

2024 оны төсөв батлагдахад багаж техник хэрэгсэлд 5,000.0 мянган төгрөгийн төсөв батлагдсан, зарцуулах эрхийн хүрээнд ажлын зайлшгүй шаардлагаар Мегабоард XXK шууд худалдан авалтаар epson маркийн проектор, сканер авсан, Монгол улсын засгийн газрын 2024 оны 7 дугаар сарын 24 -ний өдрийн 06 дугаар тогтоолоор Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар болж өргөжсөнтэй холбоотойгоор 2024 оны 11 дүгээр сарын 21-ний 248 дугаар албан бичгээр Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яаманд хүсэлт хүргүүлж 67,274.9 мянган төгрөгийн санхүүжилтийг 12 дугаар сард шийдүүлсэн.

Төсвийн хуваарьт зохицуулалт хийгдсэний үндсэн дээр 2024 оны 12 дугаар сард Алтайн мөнх уул XXK -тай шууд худалдах гэрээ хийж 7 нэр төрлийн 11 ширхэг 19,979.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан байна. Худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ц.Дорж гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 12 дугаар сарын 24 -ний өдрийн 277 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2024 оны төсвийн хөрөнгийг захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг Соёл, урлаг аялал жуулчлал, залуучуудын газрын дарга Б.Пүрэвдагва, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Б.Мөнхтогтох нар зурж байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны батлагдсан төсөв 556,735.8 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 5,567.4 мянга, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 65 хувиар буюу 3,618.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6.5.4 заасны дагуу цалин, ажил олгогчоос төлөх НДШ зардлаас 16,643.4 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас 383.2 мянган төгрөг, тэтгэмжээс 836.9 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн данснаас 3,643.3 мянган төгрөг нийт 21,651.2 мянган төгрөгийн хэмнэлт гарч улсын ***төсөвт төвлөрүүлсэн байна***.

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлбэл зохих хуулийн 6.4.5 "Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээ"-д заасан орлогын 596,735.8 мянган төгрөгийн 32 гүйлгээ, зарлагын 51,736.9 мянган төгрөгийн 7 гүйлгээ, өмч хөрөнгө орлогод авах, мөнгө зарцуулахтай холбоотой 410,005.6 мянган төгрөгийн 41 шийдвэрийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлсэн байна.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тайлант хугацаанд завсар үеийн аудит хийгдээгүй болно.

#### 4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Азбаяр гүйцэтгэж аудитаар 87.1 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 2,371.0 мянган төгрөгийн алдаа зөрчил давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгснийг бүрэн биелүүлсэн талаар тус байгууллагаас 2024 оны 03 дугаар сарын 19 -ний өдрийн 70 дугаартай албан бичгээр ирүүлэн, FAS программд хэрэгжилтийг мэдээлж ажилласан байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Төлбөрийн акт | 1 | 87.1 | 1 | 87.1 | 100% |
| Зөвлөмж | 1 | 2,371.0 | 1 | 2,371.0 | 100% |
| **Нийт дүн** | **2** | **2,458.1** | **2** | **2,458.1** | **100%** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд төрийн алба хаагч ажлын байрны тодорхойлолтод заагдсан үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд илүү цагийн хөлсийг хавтгайруулан олгохгүй байх.

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ООРЧЛОЛТГҮЙ САЛАЛ ДУГААТ

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 21,338.1 мянган төгрөгийн 1 алдаа[1] илэрснээс аудитын явцад залруулав. Үүнд:

1. Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын даргын 2024.04.03 -ний өдрийн 26 дугаар захирамжаар анхны өртөг нь 140,831.7 мянган төгрөг, хуримтлагдсан элэгдэл 21,338.1 мянган төгрөг, үлдэх өртөг 119,493.6 мянган төгрөгийн барилгыг үлдэх өртөг 119,493.6 мянган төгрөгөөр барилга байгууламж дансанд бүртгэсэн нь УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, мөн толилуулга гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Аудитаар нийт 670.0 мянган төгрөгийн зөрчил[2] илэрснээс 670.0 мянган төгрөгийн төлбөрийн 2 акт тогтоож, 1 зөвлөмж өгсөн.

### 5.1 Төлбөрийн акт

5.1.1 Албан хаагчид томилолтоор ажилласан хугацаанд хоолны нөхөн олговрын 490.0 мянган төгрөгийг давхардуулан олгосон байна.

Энэ нь Сангийн сайдын 2024.04.01-ний өдрийн “Дотоод албан томилолтын зардлын хэмжээг шинэчлэн батлах тухай” А/50 дугаар тушаалын 1 дэх заалтыг зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь:* Албан хаагчдад давхардуулан олгосон 490.0 мянган төгрөгийн хоолны зардлыг буруутай албан тушаалтнаар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.1.2 Баримт нь эх хувиараа байхгүй, хувилсан томилолтын хуудсыг үндэслэж дотоод албан томилолтын зардлаас 180.0 мянган төгрөгийг олгосон байна.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно. 14 дүгээр зүйлийн 14.3.1-т анхан шатны баримт бүрдүүлэх. 20 дугаар зүйлийн 20.2.3-т холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах; гэсэн заалтыг зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь:* Албан хаагчдад олгосон 180.0 мянган төгрөгийн дотоод албан томилолтын зардлыг буруутай албан тушаалтнаар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

### 5.2 Албан шаардлага

Байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд төрийн алба хаагч ажлын байрны тодорхойлолтод заагдсан үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд байгууллагын даргын 2024 оны Б/11, Б/33, Б/38 дугаар тушаалуудаар 8,926.2 мянган төгрөгийн илүү цагийн хөлсийг хавтгайруулан олгосон байна.

---

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

005 ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.13. албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийн хэрэгжилтийг хангах, 37.1.16. Хөдөлмөрийн тухай хууль, байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу ажлын цагийг үр бүтээлтэй ашиглах, 91 дүгээр зүйлийн 91.2-т "Дараах тохиолдолд ажилтныг илүү цагаар ажиллуулж болно гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно", 12.1.4 дэх "хуулиар зөвшөөрөөгүй бусад", Хөдөлмөрийн тухай хуулийн 91 дүгээр зүйлийн 91.2-т "Дараах тохиолдолд ажилтныг илүү цагаар ажиллуулж болно" заасан нөхцөл байдал үүсээгүй, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2-т "Төрийн албаны тухай хуульд тусгайлан зааснаас өөрөөр төрийн албан хаагчид нэмэгдэл, нэмэгдэл хөлс тогтоохгүй байхыг төсвийн байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн төвлөрүүлэн захирагч, төсвийн шууд захирагч нарт даалгасугай" гэсэн заалтыг тус тус зөрчсөн тул зөрчлийг арилгуулах албан шаардлага өгч байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл** /мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Аймгийн ИТХ -ын даргын 2024.04.03 -ний өдрийн 100 дугаар захирамжаар | 1 | 21,338.1 | | | 1 | 21,338.1 | 1 | 21,338.1 | | |
| Дүн | 1 | 21,338.1 | | | 1 | 21,338.1 | 1 | 21,338.1 | | |

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Албан хаагчид томилолтоор ажилласан хугацаанд хоолны нөхөн олговрын 490.0 мянган төгрөгийг давхардуулан олгосон байна. | 1 | 490.0 | 1 | 490.0 | | | | |
| Баримт нь эх хувиараа байхгүй, хувилсан томилолтын хуудсыг үндэслэж дотоод албан томилолтын зардлаас 180.0 мянган төгрөгийг олгосон байна. | 1 | 180.0 | 1 | 180.0 | | | | |
| Дүн | 2 | 670.0 | 2 | 670.0 | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуультай холбоотой зөрчил | | | | | | | | |
| Байхгүй | | | | | | | | |
| Төсвийн тухай хууль, Хэмнэлтийн тухай хуультай холбоотой зөрчил | | | | | | | | |
| Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно", 12.1.4 дэх "хуулиар зөвшөөрөөгүй бусад" Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.13. албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийн хэрэгжилтийг хангах, 37.1.16. Хөдөлмөрийн тухай хууль, байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу ажлын цагийг үр бүтээлтэй ашиглах. Хөдөлмөрийн тухай хуулийн 91 дүгээр зүйлийн 91.2 дахь "Дараах тохиолдолд ажилтныг илүү цагаар ажиллуулж болно", заалтуудыг зөрчсөн байна. | 1 | 8,926.2 | | | 1 | 8,926.2 | | |
| **Дүн** | **1** | | | | **1** | **8,926.2** | | |

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

------------оОо------------

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АКТ**

2025 оны 02 сарын 14 өдөр Дугаар 06 /А057/308/БНА-2025/051/НА/СТА-ТШЗ Номгон

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нэр бүхий 7 хүнд албан томилолтоор ажилласан хугацаанд хоолны нөхөн олговрын 490.0 мянган төгрөгийг давхардуулан олгосон байна.

Энэ нь Сангийн сайдын 2024.04.01-ний өдрийн "Дотоод албан томилолтын зардлын хэмжээг шинэчлэн батлах тухай" А/50 дугаар тушаалын 1 дэх заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.8 дахь "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Хууль зөрчиж олгосон 490.0 мянган төгрөгийг байгууллагын дарга, нягтлан бодогч нараар төлүүлж, төсөвт төвлөрүүлэх.
2. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2025 оны 05 дугаар сарын 15-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт

5050016

ирүүлэхийг Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын дарга Б.Пүрэвдагва, нягтлан бодогч Б.Мөнхтогтох нарт хариуцуулав[1].

**ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН[2]:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ

АУДИТОР Ц.ДОРЖ

6417143544
ВЮА0067 9007423

[1] Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

[2] Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АКТ**

2025 оны 02 сарын 14 өдөр  Дугаар 07/А051/308/ БНА-2025/051/НА/СТА-ТШ3  Номгон

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Анхан шатны баримтын шаардлага хангахгүй, баримтаар дотоод албан томилолтын зардлаас 180.0 мянган төгрөгийг олгосон байна.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно. 14 дүгээр зүйлийн 14.3.1-т анхан шатны баримт бүрдүүлэх. 20 дугаар зүйлийн 20.2.3-т холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах; гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.8 дахь “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

5050020

1. Анхан шатны баримтгүй олгосон 180.0 мянган төгрөгийг байгууллагын дарга, нягтлан бодогч нараар төлүүлж, төсөвт төвлөрүүлэх.

Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2025 оны 05 дугаар сарын 15-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын дарга Б.Пүрэвдагва, нягтлан бодогч Б.Мөнхтогтох нарт хариуцуулав[1].

**ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН[2]:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ

АУДИТОР Ц.ДОРЖ

6417143544
ВЮА0067 9007423

[1] Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

[2] Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 14 өдөр Дугаар 14 /А0517308/ БНА-2025/0511 НА-СТА/-ТШ3 Номгон

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд төрийн алба хаагч ажлын байрны тодорхойлолтод заагдсан үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд байгууллагын даргын 2024 оны Б/11, Б/33, Б/38 дугаар тушаалуудаар 8,926.225 төгрөгийн илүү цагийн хөлсийг хавтгайруулан олгосон байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.13. албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийн хэрэгжилтийг хангах, 37.1.16. "Хөдөлмөрийн тухай хууль, байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу ажлын цагийг үр бүтээлтэй ашиглах", Хөдөлмөрийн тухай хуулийн 91 дүгээр зүйлийн 91.2 дахь "Дараах тохиолдолд ажилтныг илүү цагаар ажиллуулж болно" заалтууыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх "Хууль, тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

5040040

1. Байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд төрийн алба хаагч ажлын байрны тодорхойлолтод заагдсан үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд илүү цагийн хөлсийг хавтгайруулан олгож байгаа зөрчлийг арилгах.

2. Албан шаардлагын биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын 15-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт[1] ирүүлэхийг Баянхонгор аймгийн Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын дарга Б.Пүрэвдагва, нягтлан бодогч Б.Мөнхтогтох нарт хариуцуулав[2].

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН [3]:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ

АУДИТОР Ц.ДОРЖ

6417143544
ВЮА0067 9007423

[1] Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

[2] Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

[3] Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно